

**МОНГОЛ УЛС БОЛОН ЕВРАЗИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ХОЛБОО, ТҮҮНИЙ
ГИШҮҮН ОРНУУД ХООРОНДЫН ХУДАЛДААНЫ ТҮР ХЭЛЭЛЦЭЭРИЙГ
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

**Улаанбаатар
2025 он**

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл

Хоёр. Хуулийн этгээдийн зардлыг тооцох

Гурав. Иргэний зардлыг тооцох

Дөрөв. Төрийн байгууллагын зардлыг тооцох

4.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

4.2 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц болон зардлыг урьдчилан тооцох

4.3 Төрийн байгууллагад үүсэх нийт зардлыг тооцох;

4.4 Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Тав. Хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах

Ашигласан эх сурвалж

Хавсралт 1. Хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллагуудад үүрэг оногдуулсан заалтууд

НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дараах нийтлэг зарчмыг баримтлан боловсруулсан. Үүнд:

- Аргачлалд тооцоолол хийх үе шатыг баримтлах;
- Гүйцэтгэх үүрэг болон түүнд зарцуулах хугацааг оновчтой тооцоолох;
- Статистик тоо баримт

Зардал тооцоход Эдийн засаг, хөгжлийн яам, Үндэсний статистикийн хороо, Гаалийн ерөнхий газрын тоон мэдээллийг ашигласан.

Хуулийн төслийн гол зорилго нь Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-ны гишүүн орнууд болох Армени, Беларусь, Казакстан, Киргиз, Оросын Холбооны Улс (ОХУ)-уудтай “Монгол Улс болон Евразийн эдийн засгийн холбоо, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээр”-ийн хүрээнд тохиролцсон Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем (БТКУС)-ийн 6 оронгийн түвшинд 367 мөр барааны импортын тарифын хувь хэмжээг тэглэх, бууруулах болон хоёр талын худалдааны тарифын бус саад тотгорыг багасгах, үйл ажиллагааг хялбаршуулах замаар худалдааг хөнгөвчилж, гадаад худалдаа эрхлэгчдэд таатай нөхцөл бүрдүүлэн, гадаад зах зээлийг тэлж, худалдааг өргөжүүлэн төрөлжүүлэхийг дэмжиж, тэдгээр улсуудтай хийх эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх юм.

Монгол Улсын хувьд тус хэлэлцээрийг байгуулснаар хөдөө, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, экспортыг төрөлжүүлэх, гадаад худалдааны цөөн зах зээлээс хараат байдлыг бууруулж, түнш орнуудын зах зээлд саадгүй нэвтрэх, бизнес эрхлэгчдийн орлогыг нэмэгдүүлэх, өрхийн худалдан авах чадварыг сайжруулах ач холбогдолтой байна.

Хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсаас ЕАЭЗХ-ны гишүүн орнуудад экспортлох нийт 367 мөр бараанаас 364 барааны гаалийн тарифыг тэглэж, 3 барааны тарифыг 25 болон 50 хувиар бууруулна.

Харин Монгол Улс ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас орж ирэх нийт 367 мөр барааны 356 барааг тарифаас чөлөөлж, 6 барааны тарифыг 25 болон 50 хувийг бууруулах, 3 бараанд тоон хэмжээний хязгаарлалт тогтоож, заасан хэмжээнд тарифыг бууруулах, 2 бараанд тоон хэмжээний хязгаарлалт тогтоомж, заасан хэмжээнд тарифыг тэглэх байдлаар хөнгөлөлт үзүүлэхээр байна.

Хэлэлцээрийг талууд харилцан тохиролцон сунгах боломжтой байдлаар 3 жилийн хугацаатай байгуулна.

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Худалдааны түр хэлэлцээрт хуулийн этгээдэд дараах үүргийг ногдуулсан байна. Үүнд:

- Зохих гарал үүсэлтэй барааг энэхүү Хэлэлцээрийн Тал бус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан оруулсан тохиолдолд дараах нотлох баримтын аль нэгийг импортлогч Талын гаалийн байгууллагад гаргаж өгнө¹. Үүнд:

а) нэг Талын нутаг дэвсгэрээс нөгөө Талын нутаг дэвсгэрт хүртэл тээвэрлэсэн замыг заасан, мөн тухайн барааны тодорхойлолтыг, хэрэв шаардлагатай бөгөөд тээвэрлэлтийн нөхцөлтэй нийцэж байгаа бол ашигласан хөлөг онгоцны эсхүл өөр бусад тээврийн хэрэгслийн нэр, чингэлгийн дугаарыг тусгасан тээврийн бичиг баримт; эсхүл

б) хэрэв тухайн барааг энэхүү Хэлэлцээрийн Тал тус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлсэн бол Тал бус улсын гаалийн байгууллагаас үйлдсэн тодорхойлолтыг тусгасан, мөн тухайн барааг гаалийн хяналтад байлгаж (хадгалж), өөрийн нутаг дэвсгэрт энэ Зүйлийн 1 дэх хэсгийн "а"-д заасны дагуу өөрчлөөгүй, боловсруулаагүй болохыг баталгаажуулсан баримт бичиг.

- Гарал үүслийн гэрчилгээ гаргуулах хүсэлт гаргасан үйлдвэрлэгч, экспортлогч нь эрх бүхий байгууллагад хүргүүлсэн бүх баримт бичгийн бүртгэл болон хуулбар, нотлох баримт бичиг зэргийг Гарал үүслийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш гурав (3)-аас доошгүй жилийн хугацаанд хадгална².

Хэлэлцээрийн Тал бус улсын нутаг дэвсгэрээр дамжуулан оруулсан тохиолдолд бүрдүүлэх нотлох баримтыг гаргаж өгөх үйл ажиллагаа нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Гаалийн тухай хууль болон Барааг улс хооронд дамжуулан өнгөрүүлэх гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журмын хүрээнд зохицуулагдаж байгаа тул нэмэлт зардал гарахгүй.

Гарал үүслийн нотлох баримт бичгийг хадгалах ажиллагааг экспортлогч өөрийн ажиллах хүчний нөөцийн хүрээнд шийдвэрлэх бүрэн боломжтой тул нэмэлт зардал гарахгүй.

Тиймээс Монгол Улс болон ЕАЭЗХ хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хууль хэрэгжсэнээр **хуулийн этгээдэд ямар нэг зардал үүсэхгүй.**

Харин 5000 еврогоос бага үнийн дүнтэй бараа экспортлоход гарал үүслийн гэрчилгээ шаардахгүй, экспортлогч өөрөө гаргаж өгөх боломжтой нотлох баримт бичиг, гарал үүслийн мэдүүлгийн дагуу хөнгөлөлт эдлэхээр зохицуулсан³ нь жижиг,

¹ Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм, 15 дугаар зүйл. Шууд ачилт, 2 дэх хэсэг

² Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм, 23 дугаар зүйл.

³ Хавсралт 3, Гарал үүслийн дүрэм, Гарал үүслийн мэдүүлэг 21.1.

дунд аж ахуйн нэгжүүдийн хувьд худалдааг хөнгөвчилж, зардал бууруулах эерэг нөлөөтэй байна.

ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Хуулийн төсөлд иргэний хувьд нэмж гүйцэтгэх үүрэг тусаагүй **тул иргэнд учрах зардал үүсэхгүй**. Харин дотоодын үйлдвэрлэлд өрсөлдөөн нэмэгдэж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний сонголт, хүртээмж нэмэгдэн, улмаар үнэ буурж, өрхийн зардал хэмнэгдэнэ.

Инфляцыг тооцоход ашиглагддаг өрхийн хэрэглээний бүтээгдэхүүний сагсанд нийт 429 бүтээгдэхүүн байдаг бөгөөд үүний 239 нь импортын бүтээгдэхүүн байдаг. Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээлснээр 2024 оны байдлаар дундаж өрх хэрэглээндээ жилд 31,518,237 төгрөг зарцуулсан байна.

Хэлэлцээрт хамрагдаж буй инфляц тооцоход ордог 42 бүтээгдэхүүн тарифаас чөлөөлөгдсөнөөр өрхийн хэрэглээний зардлыг жилд 193,000 төгрөгөөр бууруулахаар байна. 2024 оны байдлаар Монгол Улсын нийт өрх 997,023 байгаа ба улсын хэмжээнд нийт өрхийн хэрэглээний зардал 192.4 тэрбум төгрөгөөр буурахаар байна⁴.

ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Аргачлалын 4.1-т заасны дагуу хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолохдоо дараах дарааллыг баримталсан. Үүнд:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц, гарах зардлыг урьдчилан тооцох;
- Төрийн байгууллагад үүсэх нийт зардлыг тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах үе шатаар тооцооллыг хийсэн.

4.1 Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох

Энэ хэсэгт хуулийн төслийг судалж, тодорхой үүрэг хүлээж буй байгууллага байгаа эсэхийг тодорхойлж, уг байгууллага нь ямар ажил, үйлчилгээ шинээр гүйцэтгэх, эсхүл одоо гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээ хуулийн төслийн дагуу өргөжиж байгаа эсэхийг тогтоох юм.

Аргачлалд заасны дагуу ажил, үйлчилгээг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл, алхмыг хэт нарийвчлахгүй байх, байгууллагыг сонгохдоо тухайн ажил, үйлчилгээнд хамааралтай бүх байгууллагыг биш голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох, ажил, үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамруулах зарчмыг баримталсан.

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн 10, 11, 13, 14, 23, 26, 27 дугаар зүйл, Хавсралт 3. Гарал үүслийн дүрмийн 3, 28, 29 дүгээр зүйлд төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээтэй холбоотой зохицуулалтууд туссан байна. (Хавсралт 1).

⁴ ЭЗХЯ-ны тооцоо. 2025.04 сар

4.2 Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөц болон зардлыг урьдчилан тооцох

Зардлын тооцооны 4.1 дэх хэсэгт тодорхойлсон төрийн байгууллагын гүйцэтгэх ажил үйлчилгээнүүд нь одоо үйлчилж буй Монгол Улсын хууль, тогтоомж болон төрийн байгууллагуудын чиг үүрэгт хамаарч буй тул хүний нөөц шинээр авах шаардлагагүй бөгөөд үүнтэй холбоотой шинээр зардал үүсэхгүй (Дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 1-т оруулав).

Харин Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн Хавсралт 2 болон Хавсралт 3-т ЕАЭЗХ болон Монгол Улсын тарифын жагсаалт туссан. Хавсралтад заасан тарифын үүргийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн хувьд нэмэлт зардал гарахгүй. Харин төсвийн орлогод хэрхэн нөлөөлөх тооцооллыг хийх шаардлагатай ба тооцоог “4.3 Төрийн байгууллагад үүсэх нийт зардлыг тооцох” хэсэгт оруулсан.

4.3 Төрийн байгууллагад үүсэх нийт зардлыг тооцох

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн Хавсралт 2 болон Хавсралт 3-т туссан ЕАЭЗХ болон Монгол Улсын тарифын жагсаалтыг мөрдсөнөөр улсын төсөвт учирч болох зардлыг импортын барааны гадаад худалдааны орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогын бууралтаар тооцов.

Төсвийн орлогод үзүүлэх нөлөө

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 87.3 хувийг татварын орлого бүрдүүлдэг. Үүнээс импортын барааны гаалийн албан татварын орлого сүүлийн 3 жилийн дунджаар төсвийн нийт орлогын 6.1 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Нэгдсэн төсвийн орлого, зарим ангиллаар, их наяд төгрөгөөр

Задаргаа	2022		2023		2024	
	Орлогын хэмжээ	Эзлэх хувь	Орлогын хэмжээ	Эзлэх хувь	Орлогын хэмжээ	Эзлэх хувь
Нийт орлого ба тусламжийн дүн	18.5		24.4		31.4	
Нийт тэнцвэржүүлсэн орлого	17.1		23.3		29.6	
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	4.8	26.0%	5.6	22.9%	7.0	22.3%
Нэмэгдсэн өртгийн татвар	3.9	21.3%	4.8	19.6%	5.9	18.7%
Дотоодын бараа, үйлчилгээний албан татвар	1.5	8.2%	2.0	8.2%	2.5	8.0%
Импортын барааны	2.8	14.9%	3.2	13.0%	4.0	12.6%
НӨАТ-ын буцаан олголт	-0.3	-1.8%	-0.4	-1.6%	-0.6	-2.0%
Онцгой албан татвар	0.8	4.6%	0.8	3.2%	1.1	3.5%
Дотоодын архины	0.2	1.2%	0.2	0.9%	0.2	0.7%
Дотоодын тамхины	0.0	0.2%	0.0	0.1%	0.0	0.0%
Автобензин, дизелийн түлшний	0.1	0.5%	0.0	0.1%	0.0	0.0%
Импортын архи, пиво, тамхины	0.2	1.0%	0.2	0.8%	0.2	0.7%
Импортын пивоны	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
Суудлын автомашин	0.3	1.5%	0.3	1.3%	0.6	1.9%
Дотоодын пивоны	0.0	0.2%	0.0	0.1%	0.0	0.1%

Гадаад худалдааны орлого	1.3	6.8%	1.5	6.0%	1.8	5.7%
Импортын барааны	1.3	6.8%	1.5	6.0%	1.8	5.7%
Экспортын барааны	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн Хавсралт 2-т ЕАЭЗХ-ны гишүүн орнуудаас импортлох 367 нэр төрлийн бараанд ногдуулах Монгол Улсын тарифын чөлөөлөлт, хөнгөлөлт туссан. Энэхүү чөлөөлөлт, хөнгөлөлт нь зөвхөн импортын барааны гаалийн тарифт хамааралтай бөгөөд нэмэгдсэн өргийн албан татвар (НӨАТ), онцгой татвар, албан татварт хамаарахгүй.

2024 оны байдлаар тус 367 бараанд ногдсон татвар 1.3 их наяд төгрөг байсан ба гаалийн татварын орлого нь үүний 23.7 хувь байна. Тодруулбал,

- Гаалийн татвар: 296.8 тэрбум төгрөг (23.7% тэглэнэ)
- Албан татвар⁵: 26.0 тэрбум (2.1% тэглэхгүй)
- НӨАТ: 923.3 тэрбум төгрөг (73.6% тэглэхгүй)
- Онцгой албан татвар: 7.9 тэрбум (0.6% тэглэхгүй)

Монгол Улсын 2024 оны нийт гадаад худалдааны татвар 6.8 их наяд төгрөг (гаалийн татвар, НӨАТ, онцгой албан татвар, албан татвар) байна. ЕАЭЗХ-ны 367 барааны гаалийн татвар 296.8 тэрбум төгрөг байсан ба энэ нь нийт гадаад худалдааны татварын 4.3 хувь, нэгдсэн төсвийн тэнвэржүүлсэн орлогын 1.0 хувь байна.

Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийн хүлээгдэж буй эдийн засгийн нөлөөллийн шинжилгээг ГТАР⁶ (Дэлхийн худалдааны анализ төсөл) ерөнхий тэнцвэрийн стандарт загвар ашиглан хийсэн.

Хүснэгт 2. Хэлэлцээрийн эдийн засгийн нөлөөллийн шинжилгээний үр дүн

№	Шинжилгээний үзүүлэлт	ГТАР үр дүн
1	ЕАЭЗХ-ны улсууд руу экспорт өснө.	24.20% ЕАЭЗХ-руу экспорт 28.5 сая ам.доллараар өснө
2	МУ-ын нийт экспорт өснө.	0.21% МУ-ын нийт экспорт 68.2 сая ам.доллараар илүү өснө.
3	ЕАЭЗХ-оос импорт өснө.	0.78% ЕАЭЗХ-ны импортын өсөлт саарч 46.1 ам.доллараар өснө.
4	МУ-ын нийт импорт өснө.	0.52% МУ-ын нийт импортын өсөлт саарч 60.4 сая.доллараар өснө.
5	Хэрэглээний зардал буурна.	- 0.28% Өрхийн хэрэглээний зардал буурна.

⁵ Автобензин, дизелийн түлшний албан татварын тухай хууль

⁶ ГТАР загвар нь олон улсын худалдаа, үйлдвэрлэл, эдийн засгийн бодлого, түүний үр нөлөөг шинжлэхэд ашигладаг дэлхийн 141 улс, 19 бүс нутгийн холбогдох мэдээллийг агуулсан загвар юм. Уг загварыг АНУ, Европын холбоо, Австрали, Хятад, Япон зэрэг орнууд худалдааны бодлого, тарифын өөрчлөлт, бүс нутгийн худалдааны шинжилгээ, эрчим хүчний бодлого зэргийг шинжлэхэд ашиглаж байна. Энэхүү шинжилгээнд ГТАР мэдээллийн сангийн хамгийн сүүлийн хувилбар болох 11С дата баазыг ашигласан (2023 оны 4 дүгээр сар).

6	Хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.	2.60% Хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
7	Бодит ДНБ өснө.	0.02% ДНБ эерэг буюу 0.0008% сайжирна.
8	Худалдааны нөхцөл сайжирна.	1.33% Валютын орох урсгал илүү сайжирна.
9	Инфляц буурна.	-0.70% нэгж Инфляцын дарамт буурна.
10	Зарим квоттой болгосон барааны импортын өөрчлөлт.	Өндөг 1.80% Импортын өсөлт эрс багасна.
		Улаан буудай (- 56.10%) Импорт эрс буурна.
		Хуурай сүү (- 8.20%) Импорт эрс буурна.
		Архи, шар айраг 2.00% Импортын өсөлт эрс багасна.

Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яамны тооцоолол

ГТАР шинжилгээний үр дүнгийн дагуу хэлэлцээр хэрэгжсэнээр ЕАЭЗХ-оос импортлох бүтээгдэхүүний хэмжээ 0.78 хувь өсөх ба Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд суурь оныг 2024 оноор⁷ авч үзвэл, эхний жилд төсвийн орлого 299.1 тэрбум төгрөгөөр буурахаар байна⁸.

Хэдийгээр гаалийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөс шалтгаалан төсвийн шууд орлого буурах боловч хэлэлцээрийн үр дүнд экспорт, хөрөнгө оруулалт, дотоодын нийт бүтээгдэхүүн өсөж, инфляц буурч, өрхийн худалдан авах чадвар нэмэгдэн, эдийн засгийн өрсөлдөх чадвар сайжрах стратегийн ач холбогдолтой. Тодруулбал,

1. ГТАР шинжилгээний үр дүнгээр экспорт 68.2 сая ам.доллар буюу 245.1 тэрбум төгрөгөөр⁹ нэмэгдэнэ.
2. Инфляц 0.7 нэгжээр буурна.
3. Манай Улсын үйлдвэрлэдэггүй бүтээн байгуулалт болон хүнсний үйлдвэрлэлд зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнүүд татваргүй үнээр импортлогдоно. Импортын өртөг буурснаар импортын инфляц болон барааны үйлдвэрлэлийн зардал багасна¹⁰. Тухайлбал:

Талх, нарийн боовны үйлдвэрийн түүхий эд орц 1 тонн тутамд

- Элсэн чихэр 131,169 төгрөг,
- Маргарин тос 194,413 төгрөг,
- Хуурай сүү 607,112 төгрөг тус тус өртөг буурна.

Өндөг, тахианы аж ахуйн нэгж түүхий эд орц 1 тонн тутамд

⁷ 2025 оны 9 дүгээр сарын байдлаар ЕАЭЗХ-ны гишүүн улсуудын импорт 2.1 тэрбум ам.доллар байгаа ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4% буурсан үзүүлэлттэй байна.

⁸ Хэлэлцээрт хамрагдах, ЕАЭЗХ-ноос импортлох 367 төрлийн барааны гаалийн татвар болон албан татварыг тооцохдоо Үндэсний нэн тааламжтай нөхцөл (MFN) баримталсан. Тухайлбал улаан буудайн тэжээл 5% тарифтай нөхцөлөөр тооцоолол хийсэн бол бусад бяслагт 15%-с 50 хувь бууруулж 7.5%-иар гаалийн тариф тооцсон.

⁹ Монголбанкны 2025.09.08-ны өдрийн албан ханшийг зардлын тооцоонд ашиглав. 1 ам.доллар= 3596.6 төгрөг.

¹⁰ ЭЗХЯ-ны тооцоо. ҮСХ-ны 2025 оны 4 дүгээр сарын тоон мэдээлэл болон Монголбанкны 2025.04.15-ны өдрийн албан ханшийг тооцоонд ашигласан.

- Шар буурцгийн шахдас 104,169 төгрөг,
 - Шар буурцгийн тос 413,289 төгрөгөөр тус тус буурна.
- Газар тариалангийн аж ахуйн нэгж түүхий эд орц 1 тонн тутамд
- Азотын бордоо 50,489 төгрөг,
 - Дизелийн түлш 147,000 төгрөгөөр тус тус буурна.
 - Малын тэжээл 1 тонн тутамд
 - Улаан буудайн хивэг тэжээл 22,493 төгрөгөөр тус тус буурна.
- Уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эд орц 1 тонн тутамд
- Хүхрийн хүчил 43,493 төгрөг,
 - Дарь, тэсрэгч бэлдмэл 543,333 төгрөгөөр тус тус буурна.
4. Хэлэлцээрийн үр дүнд уул уурхай, газар тариалангийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээгээр шаардагдах дизель түлш 1 тонн тутамд 139,785 төгрөг буурах боломжтой.
 5. Инфляцыг тооцоход ашиглагддаг өрхийн хэрэглээний бүтээгдэхүүний сагсанд нийт 429 бүтээгдэхүүн байдаг бөгөөд үүний 239 нь импортын бүтээгдэхүүн байдаг. ҮСХ-ны мэдээлснээр 2024 оны байдлаар дундаж өрх хэрэглээндээ 31,518,237 төгрөг зарцуулсан байна. Хэлэлцээрт хамрагдаж буй инфляц тооцоход ордог 42 бүтээгдэхүүн тарифаас чөлөөлөгдсөнөөр өрхийн хэрэглээний зардлыг жилд 193,000 төгрөгөөр бууруулахаар байна. 2024 оны байдлаар Монгол Улсын нийт өрх 997,023 байгаа ба нийт 192.4 тэрбум төгрөгөөр зардал буурахаар байна.
 6. Манай экспортлогч аж ахуй нэгжүүд жилд хамгийн багадаа 16.6 сая ам.доллар буюу 59.7 тэрбум төгрөгийн гаалийн татвар тэглүүлэх бөгөөд энэ хэмжээний мөнгөн урсгал дотоодод үлдэх, бизнесийн эргэлтэд орох боломж бүрдэнэ.
 7. Хэлэлцээрийн хүрээнд гарал үүслийн уян хатан нөхцөл тохирсон тул БНХАУ, БНСУ зэрэг орноос импортолсон барааг Монгол улсад савлах, шошголох, бага зэрэг боловсруулах замаар нэмүү өртөг шингээж ЕАЭЗХ-ийн гишүүн орнуудад илүү өрсөлдөх чадвартай үнээр экспортлох боломжтой болсон. (Барааны өртгийн 50-60 хувь Монгол Улсад бий болсон буюу Монголд нэмүү өртөг шингэсэн байх шаардлагатай.)

ТАВ. ХЯЛБАРЧЛАХ БОЛОМЖИЙГ ШАЛГАЖ, ҮР ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Зардлын тооцооноос дүгнэхэд хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор иргэн, хувийн хэвшил болон төрийн байгууллагад хүний нөөц болон үйл ажиллагааны нэмэлт зардал гарахгүй ба одоо хэрэгжиж буй хууль, тогтоомж, төрийн байгууллагын чиг үүргийн хүрээнд шаардлагатай зохицуулалтууд хийгдэх боломжтой.

Харин ЕАЭЗХ-ны улсуудаас импортлох 367 төрлийн бүтээгдэхүүний гаалийн тарифыг хөнгөлөх, чөлөөлөх явцад улсын төсвийн орлого богино хугацаанд жилд дунджаар 299.1 тэрбум төгрөгөөр буурахаар байгаа боловч хуулийн төслийг хэрэгжүүлснээр эдийн засагт өргөн хүрээтэй эерэг нөлөө гарахаар байна.

Нэгдүгээрт, өрхийн хэрэглээний зардал буурах шууд үр ашиг бий болно. Гаалийн тарифаас чөлөөлөгдөж буй 42 нэр төрлийн бүтээгдэхүүн өрхийн хэрэглээний сагсанд ордог тул нэг өрх жилд дунджаар 193 мянган төгрөгийн зардал хэмнэж, нийт өрхийн хэмжээнд жил бүр 192.4 тэрбум төгрөгийн хэмнэлт үүсэхээр байна.. Энэ дүнгээр хэрэглэгчдийн бодит орлого нэмэгдэнэ.

Хоёрдугаарт, экспортын боломж нэмэгдэнэ. Хэлэлцээр хэрэгжсэнээр ЕАЭЗХ-ны орнууд руу хийх экспорт 24.2 хувиар өсөж, нийт экспорт 68.2 сая ам.доллараар нэмэгдэхээр байна. Энэ нь экспортлогч аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар, орлогыг нэмэгдүүлнэ. Хуулийн төсөл хэрэгжсэнээр Монгол Улсын экспортлогчид жилд хамгийн багадаа 59.7 тэрбум төгрөгийн гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

Гуравдугаарт, хэлэлцээр хэрэгжсэнээр бий болох үйлдвэрлэлийн орцын зардлын бууралт нь эдийн засгийн бүтээмжийг нэмэгдүүлнэ. Тухайлбал, хүнсний үйлдвэрлэл, газар тариалан, уул уурхайн салбарт түлш, түүхий эд, тэжээл, бордоо зэрэг зайлшгүй шаардлагатай орцын үнэ 5–15 хувиар буурснаар, зардлын дарамт багасна. Энэ нь урт хугацаанд дотоодын үйлдвэрлэл өргөжих, ажлын байр нэмэгдэх, татварын бусад эх үүсвэр өсөхөд нөлөөлнө.

Дөрөвдүгээрт, инфляц буурах нь бодлогын чухал давуу тал юм. Импортын үнийн бууралтаар дамжин инфляц 0.7 нэгжээр багасах тооцоо гарсан нь өрхийн бодит худалдан авах чадварыг нэмэгдүүлэхийн зэрэгцээ макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой.

Ийнхүү нэг талаас гаалийн татварын орлого буурч байгаа боловч нөгөө талаас өрхийн хэрэглээний зардлын бууралт, дотоодын нийт бүтээгдэхүүн, хөрөнгө оруулалт болон экспортын орлогын өсөлт, үйлдвэрлэлийн орцын зардлын бууралт, инфляцын бууралт зэрэг эдийн засагт их хэмжээний шууд болон дам эерэг нөлөөлөл үүсгэнэ.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

- Гаалийн тухай хууль
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль
- Олон улсын гэрээний тухай хууль
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль
- Ургамал хамгааллын тухай хууль
- Хүнсний тухай хууль
- Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал
- www.1212.mn
- www.nso.mn
- www.gaali.mn

Хавсралт 1. Монгол Улс болон ЕАЭЗХ, түүний гишүүн орнууд хоорондын худалдааны түр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэрэгжүүлснээр төрийн байгууллагад ногдуулах үүрэгтэй холбоотой заалтууд.

Зүйл	Хэсэг, зохицуулалт	Зардлын тооцоо хийх шаардлагатай эсэх тайлбар
10 дугаар зүйл Худалдаан дахь техникийн саад тотгор	4. Заавал биелүүлэх шаардлагад бараа нийцэж байгаа эсэх тухай тохирлыг үнэлэх шаардлага, аргачлалыг импортлогч Талын холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу болон ДХБ-ын хэлэлцээрийн Хавсралт 1А-гийн Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн зүйл, заалтуудад нийцүүлэн Талуудын холбогдох эрх бүхий байгууллага тодорхойлно. 6. Талуудын нэг нь нөгөө Талын авсан арга хэмжээ нь худалдаанд шаардлагагүй саад тотгор үүсгэсэн, эсхүл үүсгэж болзошгүй гэж үзсэн тохиолдолд Талууд харилцан хүлээн зөвшөөрч болох шийдвэрт хүрэх зорилгоор Хамтарсан хорооны хүрээнд техникийн зөвлөлдөх уулзалт хийнэ. Техникийн зөвлөлдөх уулзалтыг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> 4-д заасан үйл ажиллагаа Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ. Энэ хуулиар Гадаад худалдааны барааны тохирлын үнэлгээ нь олон улсын стандарт, тухайлбал ДХБ-ын Техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн шаардлагад нийцсэн байна. 6-д заасан худалдаанд саад тотгор үүссэн асуудлыг Эдийн засаг, хөгжлийн яам, эсхүл Гадаад харилцааны яам нөгөө талтай дипломат болон техникийн түвшинд хэлэлцээр хийх замаар шийдвэрлэх боломжтой.
11 дүгээр зүйл Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ	3. Хоорондын худалдаанаас үүссэн, эсхүл үүсэж болзошгүй амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээтэй холбоотой аливаа асуудлын талаар нэг Тал бичгээр хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө Тал цаг тухайд нь мэдээллийг гаргаж өгнө. 4. Хэрэв нэг Тал нь нөгөө Талыг худалдаанд далд хориг үүсгэх, эсхүл үүсгэсэн арга хэмжээг авсан гэж үзвэл Хамтарсан хорооны хүрээнд Талууд тохиролцон техникийн зөвлөлдөх уулзалт хийнэ. Техникийн зөвлөлдөх уулзалтыг Талуудын харилцан тохиролцсон аливаа хэлбэрээр зохион байгуулж болно.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Монгол Улсын Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Ургамал хамгааллын тухай хууль болон Хүнсний тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ.
13 дугаар зүйл. Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөх	6. Талууд тэдгээрийн хоорондын худалдааг хөнгөвчлөх үүднээс барааг түргэн шуурхай олгоход чиглэсэн гаалийн горим, арга ажиллагаа баталж, эсхүл тийм горим, арга ажиллагаатай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөнө. Энэ нь аль нэг Талын бараа олгоход тавьсан шаардлага хангагдаагүй тохиолдолд уг барааг олгохыг тухайн Талаас шаардаагүй болно. 7. Талууд энэхүү зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> 6, 7-д заасан үйл ажиллагаа нь Монгол Улсын Гаалийн тухай

	дараах арга хэмжээг авна: (а) Талуудын гаалийн хууль тогтоомж, дүрэм журамд өөрөөр зааснаас бусад тохиолдолд, барааг гаалийн мэдүүлгийг бүртгэснээс хойш 4 цагаас илүүгүй хугацааны дотор олгохоор заах; (b) бараа ирмэгц түргэн шуурхай олгох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор гаалийн мэдээллийг бараа ирэхээс өмнө цахимаар илгээх болон боловсруулах журам батлах, эсхүл тийм журамтай бол цаашид үргэлжлүүлэн мөрдөх; (с) хяналт шалгалтыг өндөр эрсдэлтэй бараанд төвлөрүүлэх, бага эрсдэлтэй бараанд хамаарах гаалийн арга ажиллагааг хялбарчлах зорилгоор эрсдэлийг системтэй үнэлэх боломжтой эрсдэлийн удирдлагын системийг хэрэгжүүлэх. 8. Талууд цаашид Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгж (ИААН)-ийн хөтөлбөр гэх аюулгүй байдлын тодорхой шалгуур хангасан аж ахуйн нэгжид зориулсан худалдааг хөнгөвчлөх түншлэлийн хөтөлбөрийг Дэлхийн гаалийн байгууллагын Дэлхийн худалдааг аюулгүй байлгах, хөнгөвчлөх Аюулгүй байдлын багц стандартын дагуу хэрэгжүүлнэ. 9. Талууд дараах байдлаар хамтран ажиллахыг эрмэлзэнэ: (а) тэдгээрийн ИААН-ийн холбогдох хөтөлбөрийг хэрэгжүүлсэн болон сайжруулсан туршлагаасаа солилцох, боломжтой бол шилдэг туршлагаудаас нэвтрүүлэхийг эрмэлзэх; (b) хөтөлбөр тус бүрийн дагуу итгэмжлэл авсан аж ахуйн нэгжүүдийн талаарх мэдээллийг тус тусын Талын хууль тогтоомж болон тогтсон журмын дагуу харилцан солилцох; (с) Нөгөө Талын итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжид худалдааг хөнгөвчлөх чиглэлээр үзүүлэх хөнгөлөлтийг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хамтран ажиллах.	хууль болон Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ. Гаалийн ерөнхий газар нь барааг түргэн шуурхай олгох, эрсдэлийн удирдлагын систем ашиглан хяналт шалгалтыг автоматжуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг. 8, 9-т заасан үйл ажиллагаа нь Гаалийн тухай хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд ИААН-ийн хөтөлбөрийг Гаалийн ерөнхий газар олгодог. Олон улсын хэмжээнд гаалийн хяналт, хамтын ажиллагааны хөтөлбөрүүдэд нэгдэж, мэдээлэл солилцох нь журмаар зохицуулагдаж байна. Одоогоор Монгол Улсад 6 аж ахуйн нэгж итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрт хамрагдсан байна.
14 дүгээр зүйл Гаалийн хамтын ажиллагаа	3. Аль нэг Талаас энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлт нь бичгээр байх бөгөөд түүнд тухайн мэдээллийг ямар зорилгоор хүсэж байгаа талаар тодорхой бичсэн, мөн тухайн барааг ялган таних хангалттай мэдээллийг хавсаргасан байна. Хүсэлтийг энэ Зүйлийн 6 дахь хэсэгт заасан харилцаа холбооны сувгийг ашиглан цахим хэлбэрээр дамжуулна. Мөн хүсэлтийн цаасан хувийг шуудангаар илгээнэ. Энэхүү зүйлд заасан бүх хүсэлт, тэдгээрийн бүх хариуг англи хэл дээр илгээнэ. 4. Энэхүү зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гаргасан хүсэлтийг хүлээн авсан Талын гаалийн байгууллага нь уг хүсэлтэд заасан мэдээлэл агуулсан хариуг өөрийн Талын холбогдох хууль тогтоомж болон дүрэм журмын дагуу, уг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 2 (хоёр) сарын дотор бичгээр гаргаж өгнө. Хариуг тогтоосон хугацаанд бүрэн, эсхүл хэсэгчилсэн байдлаар гаргаж өгөх боломжгүй бол хүсэлт хүлээн авсан гаалийн байгууллага нь хүсэлт гаргасан гаалийн байгууллагад тухайн мэдээллийг гаргаж өгөх тодорхой хугацааг мэдэгдэнэ. 6. Талуудын гаалийн байгууллагууд мэдээллийг түргэн шуурхай бөгөөд аюулгүй байдлаар солилцох, мөн	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн дагуу Гаалийн ерөнхий газар нь гадаадын гаалийн байгууллагуудтай мэдээлэл солилцох, хамтран ажиллах эрх, үүрэгтэй байдаг бөгөөд энэ хүрээнд бүрэн хэрэгжинэ.

	гаалийн асуудлыг зохицуулах ажлыг боловсронгуй болгох явдлыг хөнгөвчлөх үүрэг бүхий холбоо барих этгээдүүдийг томилох зэргээр гаалийн хамтын ажиллагааны харилцаа холбооны сувгууд бий болгож, ажиллуулахыг эрмэлзэнэ. 7. Гаалийн байгууллага ба худалдааг хөнгөвчлөхөд хамаарах тодорхой асуудлуудыг хэлэлцэх техникийн уулзалтуудыг Талуудын тохиролцсон хугацаа, газарт зохион байгуулна. 10.Талууд мэдээллийг цахимаар солилцохдоо ЕАЭЗХ-ны Мэдээллийн нэгдсэн системийн техникийн дэд бүтэц болон Монгол Улсын холбогдох дэд бүтцийг ашиглана.	
23 дугаар зүйл Цахим худалдаа	9. Талууд дотоодын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу хувийн мэдээллийг хамгаалах, түүний дотор хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулах болон хувийн мэдээллийг хил дамнуулан дамжуулахтай холбогдох нөхцөл, шаардлагыг хангах арга хэмжээг баталж, хэрэгжүүлнэ. 10. Тал тус бүр энэхүү зүйлийн хэрэгжилтээс үүдэх аливаа асуудлаар нөгөө Тал болон Хамтарсан хороотой харилцах харилцааг хариуцах холбоо барих этгээдийг томилно.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> 9-д заасан арга хэмжээ нь Монгол Улсын Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хүрээнд хэрэгжинэ. 10-т заасан Холбоо барих этгээдийг асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон харьяа байгууллагын одоо ажиллаж буй хүний нөөцийн хүрээнд шийдвэрлэх боломжтой.
26 дугаар зүйл Хамтарсан хороо	1. Талууд нь Хэлэлцээрийн Тал бүрийн төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан хороог байгуулах ба тус хороог хоёр төлөөлөгч хамтран даргалах ба нэг төлөөлөгч нь ЕАЭЗХ болон түүний гишүүн орнуудыг төлөөлж Евразийн Эдийн Засгийн Комиссын Удирдах зөвлөлийн гишүүн, нөгөө төлөөлөгч нь Монгол Улсын Эдийн засаг, хөгжлийн яам ба/эсхүл түүнийг залгамжлагч этгээд байна. Энэхүү зорилгоор зохих ёсоор эрх олгогдсон өндөр албан тушаалтнууд Талуудыг төлөөлнө. 2. Талууд Хамтарсан хорооны хуралдаан болохоос 30 (гуч)-аас ихгүй хоногийн өмнө Хамтарсан хороонд томилсон тус тусын төлөөлөгчийн талаар харилцан мэдэгдэнэ. 3. Хамтарсан хороо нь дараах чиг үүрэгтэй байна: - энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилт, үйл ажиллагаатай холбоотой бүх асуудалд хяналт тавих, шалгах; - Талуудын хоорондын худалдааны харилцааг цаашид хөгжүүлэх боломжийг судлах; - энэхүү Хэлэлцээрт оруулах нэмэлт, өөрчлөлтийг судалж, Талуудад хэлэлцүүлэхээр хүргүүлэх; мөн	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Хамтарсан хороог Хэлэлцээрийн хэрэгжилтэд хамаарах төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан байгуулах ба тэдгээр нь ажлын байрны үүргийн хүрээнд олон улсын гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, ажлын хэсэг, хороонд оролцох үүрэгтэй тул нэмэлт зардал үүсэхгүй. Энэ тохиолдолд Эдийн засаг, хөгжлийн яам болон Гадаад харилцааны яам,

	d. энэхүү Хэлэлцээрийн хамрах хүрээ, зорилгын хүрээнд Талуудаас тус Хамтарсан хороонд даалгасан Хэлэлцээрт хамаарах аливаа асуудалтай холбоотой бусад үйл ажиллагааг хэрэгжүүлэх. 6. Талууд өөрөөр тохиролцоогүй бол Хамтарсан хорооны хуралдааныг дор хаяж жил тутам тухай бүр Талуудад ээлжлэн хуралдуулна. 7. Талууд Хамтарсан хорооны үйл ажиллагааны дүрмийг нэгтгэн боловсруулж, Хамтарсан хорооны анхны хуралдаанаар батална.	Гаалийн ерөнхий газар зэрэг холбогдох байгууллагаас ажиллах боломжтой.
27 дугаар зүйл Холбоо барих этгээд	1. Энэхүү Хэлэлцээрийн үр дүнтэй хэрэгжилтийг хангах болон энэхүү Хэлэлцээрт хамаарах аливаа асуудлаар Талуудын хоорондын харилцаа холбоог дэмжихийн тулд Тал тус бүр энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 1 (нэг) сарын дотор холбоо барих этгээд эсхүл холбоо барих этгээдүүдийг томилж, нөгөө Талд мэдэгдэнэ. Талууд харилцах этгээдийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлд оруулсан аливаа өөрчлөлтийг нөгөө Талдаа даруй мэдэгдэнэ. 2. Талуудын холбоо барих этгээд нь дор дурдсан үүрэгтэй байна: (a) нөгөө Талаас гаргасан санал эсхүл хүсэлтийг хүлээн авах; (b) энэхүү хэсгийн (a) заалтад дурдсан санал, хүсэлтэд хариу өгөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тухайн Талын холбогдох бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Энэ нь олон улсын гэрээ хэлэлцээр хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг зохицуулалт бөгөөд Монгол Улсын холбогдох яам, агентлагууд өөрийн чиг үүргийн хүрээнд албан ёсны холбоо барих ажилтныг томилж ажиллуулах боломжтой.
Хавсралт 1. Евразийн эдийн засгийн холбооны тарифын жагсаалт	Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.	<u>Тийм. Хэлэлцээрт оролцогч талуудын барааны гаалийн тарифыг хэрэгжүүлснээр эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцсон.</u>
Хавсралт 2 Монгол Улсын тарифын жагсаалт	Энэ Хавсралтад заасан зохих гарал үүсэлтэй бараанд аль нэг Тал ногдуулсан гаалийн татварын хувь хэмжээ Талууд тохиролцон энэ Хавсралтын 4 дүгээр баганад заасан холбогдох хувь хэмжээнээс ихгүй байна.	
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 28 дугаар зүйл: Мэдээллийн веб сан ашиглах, гарал үүслийн мэдээллийг цахимаар солилцох систем хөгжүүлж, нэвтрүүлэх	1. Тарифын хөнгөлөлт эдлэх журмыг хялбарчлах зорилгоор Талууд олгосон гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл агуулсан бөгөөд олгосон аливаа гарал үүслийн гэрчилгээ үнэн зөв эсэхийг импортлогч Талын гаалийн байгууллагаас шалгах боломжийг бүрдүүлсэн, итгэмжлэгдсэн байгууллагуудын аюулгүй мэдээллийн веб сан (цаашид “мэдээллийн веб сан” гэх)-г ашиглаж болно. 4. Хэрэв Талууд мэдээллийн веб сан ашиглаж байгаа бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд тухайн гарал үүслийн гэрчилгээний хуулбар (цаасан, эсхүл файл хэлбэртэй), эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ нь тарифын хөнгөлөлт үзүүлэхэд хангалттай. 5. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний талаарх мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр мэдээллийн веб санд ороогүй байвал зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Монгол Улсын Гаалийн тухай хуулиар гаалийн мэдээллийн сангийн асуудал зохицуулагдаж байгаа ба Гаалийн ерөнхий газар нь гадаад худалдааны мэдээлэл, тэр дундаа гарал үүслийн гэрчилгээний мэдээллийг цахим

	заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд импортлогч Талын гаалийн байгууллага оригинал гарал үүслийн гэрчилгээ гаргаж өгөхийг шаардана. 8. Хэрэв Талууд EODES-ийг нэвтрүүлсэн бол импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн оригинал гэрчилгээ, түүний хуулбар, эсхүл гарал үүслийн цахим гэрчилгээ шаардахгүй. Энэ тохиолдолд, тарифын хөнгөлөлт зорилгоор тухайн гарал үүслийн гэрчилгээний огноо, дугаарыг гаалийн мэдүүлэгт тусгасан байна. 9. Хэрэв гарал үүслийн гэрчилгээний мэдээлэл гаалийн мэдүүлгийг бүртгэсэн өдөр EODES-т ороогүй байвал импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг шаардаж, түүний үнэн зөв эсэхийг мэдээллийн веб сан ашиглан шалгана. Хэрэв итгэмжлэгдсэн байгууллагад мэдээллийн веб сан байхгүй бол зөвхөн энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгосноос бусад тохиолдолд гарал үүслийн гэрчилгээний эхийг гаргаж өгнө.	хэлбэрээр солилцох, мэдээллийн сан ашиглах эрхтэй. Одоогийн Цахим гааль болон Эрсдэлийн удирдлагын системүүдийг ашиглан энэхүү үүргийг хэрэгжүүлэх боломжтой юм. Мөн гадаад худалдааны цахим нэг цонх нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба энэ хүрээнд шийдвэрлэх бүрэн боломжтой.
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 29 дүгээр зүйл: Гарал үүслийг шалгах	1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхэд, мөн/эсхүл уг гарал үүслийн нотлох баримтад заасан бараа нь энэхүү Дүрмийн 3 дугаар зүйлд заасан гарал үүслийн шалгуурт нийцэж байгаа эсэхэд эргэлзэж байгаа бол, эсхүл санамсаргүй сонголтоор шалгалт хийх тохиолдолд тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн бараа нь гарал үүслийн холбогдох шалгуурт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах, түүнчлэн (эсхүл), хэрэв тийнхүү хүссэн бол, тухайн барааг үйлдвэрлэгч, эсхүл экспортлогчоос нотлох баримт гаргуулах хүсэлтийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад илгээж болно (цаашид "шалгах хүсэлт" гэх). 2. Энэ Дүрмийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "b"- "g"- д заасан тохиолдолд, импортлогч Талын гаалийн байгууллага тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзсан шийдвэр гаргах зорилгоор шалгах хүсэлт гаргах шаардлагагүй. 3. Бүх шалгах хүсэлтэд тухайн барааг ялган таних хангалттай мэдээлэл, гарал үүслийн нотлох баримтын хуулбарыг хавсаргаж, тийм хүсэлт гаргах болсон нөхцөл, шалтгааныг дурдсан байна. 5. Шалгах хүсэлтийн хуулбар болон түүний дагалдах бичиг баримтууд, түүнчлэн тухайн хүсэлтийн дагуу шалгасан хариуг импортлогч Талын гаалийн байгууллага болон экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага хооронд энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ. 6. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийн хариуд экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллага нь тухайн гарал үүслийн нотлох баримт үнэн зөв эсэхийг, мөн (эсхүл) тухайн барааг тэрхүү Талын гарал үүсэлтэй гэж үзэж болох эсэхийг тодорхой зааж өгөх бөгөөд түүнд бас тухайн хүсэлтэд заасны дагуу холбогдох бараа үйлдвэрлэгчээс, эсхүл экспортлогчоос гаргуулан авсан нотлох баримтыг хавсаргасан байна. Шалгах хүсэлтийн хариуг хүлээн авахаас өмнө энэхүү Дүрмийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг ашиглаж болно. Хэрэв хүлээн авсан шалгалтын үр дүнг харахад тухайн бараа зохих гарал үүсэлтэй бөгөөд энэхүү Дүрмийн бусад бүх	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж байна.

	шаардлагыг хангасан болох нь батлагдсан бөгөөд тодорхой бол урьдчилан төлсөн гаалийн татвар болон депозитыг буцаан олгоно.	
Хавсралт 3. Гарал үүслийн дүрэм. 30 дугаар зүйл: Газар дээр нь очиж шалгах	1. Хэрэв импортлогч Талын гаалийн байгууллага энэхүү Дүрмийн 29 дүгээр зүйлд заасан шалгалтын үр дүнг хангалтгүй гэж үзвэл онцгой тохиолдолд экспортлогч Талд очиж шалгах, энэхүү Дүрмийн 23 дугаар зүйлд заасан бүртгэлтэй танилцах, мөн (эсхүл) тухайн барааг үйлдвэрлэхэд ашигласан байгууламжийг үзэж харах хүсэлт тавьж болно. 2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу шалгалтыг газар дээр нь очиж хийх үүднээс импортлогч Талын гаалийн байгууллага тийнхүү газар дээр нь очиж шалгах хүсэлтэй байгаагаа илтгэсэн хүсэлт (цаашид "газар дээр нь очиж шалгах хүсэлт" гэх)-ийг экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад бичгээр илгээнэ. Уг газар дээр нь очиж шалгах хүсэлтийн хуулбарыг импортлогч Талын гаалийн байгууллагаас экспортлогч Талын шалгах эрх бүхий байгууллагад энэхүү Дүрмийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан холбоо барих цахим шуудангийн хаягаар цахим хэлбэрээр илгээнэ. 3. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт дурдсан, газар дээр нь очиж шалгах хүсэлт нь аль болох дэлгэрэнгүй байх бөгөөд түүнд тухайлбал дараах зүйлсийг тусгасан байна: (a) тухайн Талын тийм хүсэлт гаргасан гаалийн байгууллагын нэр; (b) бараа үйлдвэрлэгч, эсхүл экспортлогч ямар байгууллагын байр агуулахыг очиж үзэх гэж байгаа; (c) газар дээр нь хэзээ очиж шалгах саналтай байгаа; (d) газар дээр нь очиж шалгах ажлын хамрах хүрээ, түүний дотор шалгах бараа, тэдгээрийн гарал үүсэл ямар асуудалтай байгаа; мөн (e) газар дээр нь очиж шалгалт хийх гэж буй эрх бүхий байгууллагын талаарх урьдчилсан мэдээлэл. 5. Газар дээр нь очиж шалгах хүсэлт гаргасан өдрөөс хойш жар (60) хоногийн дотор шалгах эрх бүхий байгууллагаас бичгээр үйлдсэн зөвшөөрөл хүлээж аваагүй, эсхүл газар дээр нь очиж шалгахыг татгалзсан хариу хүлээж авсан тохиолдолд хүсэлт гаргасан Тал газар дээр нь очиж шалгах байсан гарал үүслийн нотлох баримт(ууд)-ад дурдсан бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзана. 7. Газар дээр нь очиж шалгах ажлыг импортлогч болон экспортлогч Талуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн шалгах баг хийж гүйцэтгэнэ. 10. Хэрэв шалгуулж буй Талын эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгжийн зүгээс газар дээр нь очиж шалгах ажилд саад учруулсны улмаар газар дээр нь очиж шалгах боломжгүй болсон бол импортлогч Тал тухайн бараанд тарифын хөнгөлөлт үзүүлэхээс татгалзах эрхтэй. 14. Газар дээр нь очиж хийх шалгалтад импортлогч Талын төлөөлөгчид оролцохтой холбогдон гарах бүх зардлыг импортлогч Тал хариуцна.	<u>Үгүй. Одоо хэрэгжиж буй хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа.</u> Гаалийн тухай хуулийн хүрээнд зохицуулагдаж байгаа ба Гаалийн байгууллага гаалийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор чөлөөт эргэлтэд байгаа барааны мэдээллийн үнэн зөвийг шалгах эрхтэй. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь очиж шалгалт хийх нь энэ эрх, үүргийн үргэлжлэл юм. Уг шалгалтыг хоёр талын гаалийн байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн баг гүйцэтгэхээр заасан нь олон улсын практикт нийцсэн, хэрэгжиж болох зохицуулалт юм. Шалгалтын зардлыг импортлогч тал хариуцахаар заасан нь мөн хуулийн хүрээнд төсөвлөн шийдвэрлэх боломжтой.